



**МОНГОЛ УЛСЫН  
ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ ХҮЧНИЙ  
ЯАМ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,  
Утас: 26-35-06, Факс: (976-11) 31-81-69

2011.11.08 № 6/3923  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ  
АГЕНТЛАГ АШИГТ МАЛТМАЛЫН  
ГАЗРЫН ДАРГА Д.БАТХУЯГ ТАНАА

Тушаал хүргүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлаас “Улсын Тэмдэгтийн хураамжийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгыг 2010 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр баталсан.

Тус хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.5 дахь заалтын дагуу ашигт малтмал хайх, ашиглахтай холбогдсон үйл ажиллагаанд тэмдэгтийн хураамж авахаар зохицуулсан байна.

Үүний дагуу Үйлдвэр, худалдааны сайдын /хуучин нэрээр/ 2008 оны 181 дүгээр тушаалын /Үйлчилгээний хөлс тогтоох тухай/ нэгдүгээр хавсралтаар зохицуулсан үйлчилгээний хураамж авах зохицуулалтыг дээрх хуулийн дагуу хүчингүй болсонд тооцох, мөн тус тушаалын хоёрдугаар хавсралтаар “шуурхай үйлчилгээний хөлсний хэмжээ”-г тогтоосон нь Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 14.1.4-т “улсын төсвийн байгууллага, албан тушаалтан хуульд зааснаас бусад тохиолдолд төлбөр, хураамж авахыг хориглоно” гэж заасантай зөрчилдөж байсан тул энэхүү тушаалыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2011 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 240 дүгээр тушаалаар хүчингүй болсонд тооцсон.

Иймд энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллана уу.

Хавсралт материал 1 хуудас.

Хувийг: Хууль зүй, дотоод хэргийн яам,  
Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА  Д.ХҮРЭЛБААТАР

0804666



ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ ХҮЧНИЙ  
САЙДЫН ТУШААЛ

2011 оны 10 сарын 31 өдөр

Дугаар 240


Улаанбаатар хот


Тушаал хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг.Ашигт малтмалын хуульд нийцүүлэн гарсан нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актуудыг Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолд нийцүүлэх үүднээс Үйлдвэр, худалдааны сайдын /хуучин нэрээр/ 2008 оны 181 дүгээр тушаалыг /Үйлчилгээний хөлс тогтоох тухай/ хүчингүй болсонд тооцсугай.

Хоёр.Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ашигт малтмалын газар /Д.Батхуяг/-т даалгасугай.

САЙД  Д.ЗОРИГ



9890672